



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/166/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584. Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Д.Цэцэгмаа

Утас: Цахим хаяг:

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ...	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
2	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10

1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.АМАРСАНАА
ТАНАА

2020.01.29 № 1/19

танай _____-ны № _____-т

Г _____ 7

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа

C:\Users\audit_bhr3\Downloads\Аудитын гэрчилгээ (БНА-2020-166-СТА-ТШЗ) (1).docx

2519388

нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томсохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ХХҮГ-ын дарга Д. Амарсанаад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.18-наас 2020.01.23-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.01.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.01.07-ны өдрийн 17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар нь “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил-2019” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн үйлчилгээ үзүүлэх
- Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох
- Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн хэвийн ажиллагааг орон нутагт зохион байгуулах,
- Хүнс тэжээлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх
- Зорилтот бүлгийн өрхийн хөгжлийг дэмжих төрийн бодлогын хэрэгжилтийг ханган
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээ
- Зорилтот бүлгийн иргэдийг чадавхижуулах, хөгжүүлэх сургалт сурталчилгааны ажлыг шинэ шатанд гаргах

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон өөрчлөлт шинэчлэлт гараагүй

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Payroll" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд

байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 35 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 18 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төлөвлөлтийн шатанд сонгосон суурь үзүүлэлтийг буюу үр дүнгийн тайлангийн *нийт зардлын 1,0 хувиар* сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд сонгосон суурийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны Нийт зардал 774107,8 мянган төгрөг бөгөөд түүний 1,0 хувь болох 7,741.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1,0 хувиар тооцсон нь төлөвлөлтийн шатанд энэ хувийг сонгосонтой холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 31 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа зөрчилтэй асуудал гараагүй, залруулга хийгдээгүй болно.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	

3	Албан шаардлага өгсөн	0	0.00
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00
	Дүн	0	0.00

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд: Байхгүй

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түлш халаалтын зардлыг бодитой төлөвлөх зөвлөмж өгөгдсөний дагуу ХХҮГ нь 2019 оны төсвийн төслийг боловсруулахдаа халаалтын зардлыг бодитоор тооцон 47512,6 мянган төгрөгөөр төлөвлөж хүргүүлсэн боловч ХХҮЕГ нь өмнөх оны төлөвлөлтийн түвшинд 41552,5 мянган төгрөгөөр баталж өгснөөс тэйлэнт онд энэ зардал 5960,1 мянган төгрөгөөр хэтэрснийг цэвэр бохир усны зардлын хэмнэлтээс санхүүжүүлсэн байна. Иймд УАГ-аас ХХҮЕГ-ын нэгтгэсэн тайланд хийж буй аудитаар төлөвлөлттэй холбоотой зөвлөмжийг хүргүүлэх шаардлагатай байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбостой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 705867,2 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 700185,6 мянган төгрөг буюу 99,2 хувьтай байгаа нь батлагдсан төсвөөс 5681,6 мян. төгрөгийг хэмнэсэнтэй холбоотой байна. Хэмнэлтийн шалтгаан тайлбарыг төсөв захирагчаас гаргуулан авсан бөгөөд энэ нь тогтмол зардлын төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлого байхгүй.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	10	9	8		1
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
	Тухай бүр	13	104	104		
	Нийт	21	313	312		1

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар түлш халаалтын зардлыг бодитой төлөвлөх зөвлөмж өгсний дагуу ХХҮГ нь 2019 оны төсвийн төслийг боловсруулахдаа халаалтын зардлыг бодитоор нь тооцон төлөвлөж хүргүүлсэн боловч ХХҮГ өмнөх оны төлөвлөлтийн түвшинд баталж өгснөөс дээрх зардал тайлант онд мөн хэтэрч зарцуулагдсан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

2 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,467,761.00	7,612,924.00
33	АВЛАГА	101,761.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	101,761.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	7,366,000.00	7,612,924.00
354	Хангамжийн материал	7,366,000.00	7,612,924.00
35410	Бичиг хэргийн материал	1,725,000.00	1,466,000.00
35420	Аж ахуйн материал	5,641,000.00	6,146,924.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	215,406,423.51	220,528,868.55
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	215,406,423.51	220,528,868.55
392	Биет хөрөнгө	197,463,673.51	202,817,118.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	145,772,177.00	145,772,177.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-5,155,870.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	102,556,803.07	120,133,109.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-71,564,310.57	-88,481,670.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,726,160.00	56,835,346.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,027,155.99	-26,285,972.55
393	Биет бус хөрөнгө	17,942,750.00	17,711,750.00
39301	Програм хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-712,250.00	-943,250.00
39303	Бусал биет бус хөрөнгө	17,500,000.00	17,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	222,874,184.51	228,141,792.55
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	222,874,184.51	228,141,792.55
51	Засгийн газрын хувь өрөлцөө	222,874,184.51	228,141,792.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,454,481,459.57	1,454,481,459.57
51101	Өмч: - төрийн	1,454,481,459.57	1,454,481,459.57
512	Хуримтлагдсан үр дүн	-1,275,587,839.63	1,270,320,231.59
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,275,587,839.63	1,275,587,839.63
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	5,267,608.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,980,564.57	43,980,564.57
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	222,874,184.51	228,141,792.55

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	626,033,306.00	779,375,441.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,882,646.00	29,350,234.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,882,646.00	29,350,234.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,882,646.00	29,350,234.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,882,646.00	29,350,234.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	618,150,660.00	750,025,207.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	585,030,000.00	705,867,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	585,030,000.00	705,867,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,730,000.00	42,993,780.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,520,000.00	42,993,780.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,210,000.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,390,660.00	1,164,227.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	12,390,660.00	1,164,227.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	650,016,020.51	774,107,832.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	650,016,020.51	774,107,832.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	630,786,029.51	725,129,163.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,259,476.00	524,896,912.00
210101	Үндсэн цалин	454,259,476.00	524,896,912.00
2102	Ажил олгогчдос нийгмийн даатгалд төлөх шамтгал	55,408,395.00	66,582,427.00
210201	Тэтгэврийн даатгал	36,966,908.00	45,378,903.00
210202	Төтгөмжийн даатгал	4,619,800.00	5,321,094.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,725,830.50	4,289,559.00
210204	Ажилгүйдлийн даатгал	917,894.50	1,053,894.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,177,962.00	10,538,977.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,773,557.00	53,089,018.00
210301	Гэрэл, цахилгаан	9,417,885.00	3,425,834.00
210302	Тулш, халаалт	41,564,616.00	47,512,608.00
210303	Цэвэр, бохир ус	1,791,056.00	2,150,576.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,726,460.00	9,638,442.00
210401	Бичиг хэрэг	4,349,900.00	2,196,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,198,138.00	3,694,040.00
210403	Цуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,064,062.00	2,754,952.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,114,360.00	992,950.00

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	00.00	210,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	210,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,394,800.00	2,118,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	150,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,244,800.00	2,118,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,153,000.00	1,114,000.00
210702	Дотоод албан томилолт	1,153,000.00	1,114,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,861,520.00	40,916,818.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,804,940.00	38,459,458.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	1,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгсэлийн татвар	147,400.00	158,300.00
210805	Тээврийн хэрэгсэлийн оношлогоо	39,600.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	602,700.00	185,800.00
210807	Газрын төлбөр	166,880.00	447,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,208,821.51	26,563,046.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,208,821.51	26,563,046.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,229,991.00	48,978,669.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,376,660.00	40,866,601.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	12,390,660.00	1,164,227.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	37,052,374.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,650,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,853,331.00	8,112,068.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,853,331.00	8,112,068.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-23,982,714.51	5,267,608.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,666,666.76	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,666,666.76	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,666,666.76	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-26,649,381.27	5,267,608.04

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйцээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	618,150,660.00	750,025,207.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	618,150,660.00	750,025,207.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	585,030,000.00	705,867,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	585,030,000.00	705,867,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,730,000.00	42,993,780.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,520,000.00	42,993,780.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,210,000.00	00.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	12,390,660.00	1,164,227.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	12,390,660.00	1,164,227.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	618,150,660.00	747,296,407.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	618,150,660.00	747,296,407.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	598,920,669.00	698,317,738.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,361,237.00	524,795,151.00
210101	Үндсэн цалин	454,361,237.00	524,795,151.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,362,795.00	66,582,427.00
210201	Тэтгэврийн даатгал	37,057,213.00	45,333,918.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,663,713.00	4,249,697.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,579,641.00	5,312,126.00
210204	Ажилгүйдлийн даатгал	915,929.00	1,062,423.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,146,299.00	10,624,263.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,782,557.00	53,089,018.00
210301	Гэрэл, цахилгаан	9,417,885.00	3,425,834.00
210302	Түлш, халаалт	41,573,616.00	47,512,608.00
210303	Цэвэр, бохир ус	1,791,056.00	2,150,576.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,093,200.00	10,066,302.00
210401	Бичиг хэрэг	3,016,940.00	2,624,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,198,138.00	3,694,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,064,062.00	2,754,952.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	814,060.00	992,950.00

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2105	Нормативт зардал	213,000.00	210,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	213,000.00	210,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,168,300.00	2,169,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	707,200.00	95,500.00
210604	Урсгал засвар	1,461,100.00	2,073,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,153,000.00	1,114,000.00
210702	Дотоод албан томилолт	1,153,000.00	1,114,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,786,580.00	40,291,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,730,000.00	37,834,480.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	1,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	147,400.00	158,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	602,700.00	185,800.00
210807	Газрын төлбөр	166,880.00	447,260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,229,991.00	48,978,669.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,376,660.00	40,866,601.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	12,390,660.00	1,164,227.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	37,052,374.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	2,650,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,853,331.00	8,112,068.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,853,331.00	8,112,068.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	2,728,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	2,728,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	2,728,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	2,728,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	2,728,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-2,728,800.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,436,981,459.57	00.00	-1,248,938,458.36	00.00	188,043,001.21
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,436,981,459.57	00.00	-1,248,938,458.36	00.00	188,043,001.21
C07	Тайлант үеийн үр дүн	17,500,000.00	00.00	-26,649,381.27	00.00	-9,149,381.27
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,275,587,839.63	00.00	222,874,184.51
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,275,587,839.63	00.00	222,874,184.51
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,275,587,839.63	00.00	222,874,184.51
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,267,608.04	00.00	5,267,608.04
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,454,481,459.57	43,980,564.57	-1,270,320,231.59	00.00	228,141,792.55

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	585,030,000.00	583,176,669.00	705,867,200.00	700,185,632.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	585,030,000.00	583,176,669.00	705,867,200.00	700,185,632.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	580,044,000.00	578,190,669.00	665,765,300.00	660,483,258.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	454,797,000.00	454,781,289.00	525,441,800.00	524,795,151.00
210101	Үндсэн цалин	365,032,600.00	00.00	412,750,900.00	524,795,151.00
210102	Нэмэгдэл	70,525,400.00	00.00	93,451,900.00	00.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,239,000.00	00.00	19,239,000.00	00.00

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,095,600.00	54,942,743.00	67,620,400.00	66,582,427.00
210201	Тэтгэврийн даатгал	37,063,700.00	36,637,161.00	46,621,900.00	45,333,918.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,508,000.00	3,663,713.00	5,249,600.00	4,249,697.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,606,400.00	4,579,641.00	4,199,700.00	5,312,126.00
210204	Ажилгүйдлийн даатгал	901,600.00	915,929.00	1,049,900.00	1,062,423.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,015,900.00	9,146,299.00	10,499,300.00	10,624,263.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,769,700.00	52,782,557.00	56,125,400.00	53,089,018.00
210301	Гэрэл, цахилгаан	5,281,600.00	9,417,885.00	5,281,600.00	3,425,834.00
210302	Түлш, халаалт	39,196,800.00	41,573,616.00	41,552,500.00	47,512,608.00
210303	Цэвэр, бохир ус	9,291,300.00	1,791,056.00	9,291,300.00	2,150,576.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,093,200.00	10,093,200.00	10,093,200.00	10,066,302.00
210401	Бичиг хэрэг	3,361,000.00	3,016,940.00	3,361,000.00	2,624,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,689,800.00	4,198,138.00	2,689,800.00	3,694,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,975,900.00	2,064,062.00	2,975,900.00	2,754,952.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,066,500.00	814,060.00	1,066,500.00	992,950.00
2105	Нормативт зардал	213,800.00	213,000.00	213,800.00	210,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	213,800.00	213,000.00	213,800.00	210,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,169,600.00	2,168,300.00	2,169,600.00	2,169,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	677,100.00	707,200.00	677,100.00	95,500.00
210604	Урсгал засвар	1,492,500.00	1,461,100.00	1,492,500.00	2,073,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,563,100.00	1,153,000.00	1,563,100.00	1,114,000.00
210702	Дотоод албан томилолт	1,563,100.00	1,153,000.00	1,563,100.00	1,114,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,342,000.00	00.00	2,538,000.00	2,457,360.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	1,300,000.00	1,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	495,000.00	300,000.00	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,700.00	147,400.00	178,700.00	158,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	39,600.00	39,600.00	69,600.00	66,000.00

Баянхонгор аймгийн ХХҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	602,700.00	602,700.00	192,700.00	185,800.00
210807	Газрын төлбөр	176,000.00	166,800.00	497,000.00	447,260.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4986000.00	4986000.00	40101900.00	39702374.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,986,000.00	4,986,000.00	40,101,900.00	39,702,374.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	4,986,000.00	37,451,900.00	37,052,374.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	2,650,000.00	2,650,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	585,030,000.00	585,030,000.00	705,867,200.00	700185632.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	585,030,000.00	585,030,000.00	705,867,200.00	700185632.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	585,030,000.00	585,030,000.00	705,867,200.00	700185632.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	53.00	53.00	53.00	53.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	45.00	45.00	45.00	45.00
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	07.00	07.00

АУДИТЫН ТАЙЛАНГ:

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Д.ЦЭЦЭГМАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ 2020.01.27

ХОЁРДАХЬ ШАТАНД ХЯНАСАН: ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

2020.01.27

